



# МОНГОЛ УЛС ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2012 оны 4 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 69

Өндөрхаан  
хот

Архидан согтуурахтай тэмцэх  
талаар авах зарим арга  
хэмжээний тухай

Архидан согтуурахтай тэмцэх хууль, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2002 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амын эрүүл мэнд, амгалан тайван аж төрөхөд гол саад болж байгаа архидан согтуурах явдлыг бууруулах зорилгоор

Дэлхийн эрүүл мэндийн өдөр 4 дүгээр сарын 7, Эх үрсийн баярын өдөр 6 дугаар сарын 1, хэлтсийн шинэ жилийн нээлт 9 дүгээр сарын 1-ний өдөр согтууруулах ундаа хэрэглэдэггүй, худалддаггүй өдөр болгосугай.

*/2012 оны 04 дүгээр сарын 18-ны 128 тоот захирамжаар хүчингүй болсон./*

2. Энэ өдрүүдэд архимн хор хөнөөл, ардын ес заншлын дэвшилтэт уламжлалын талаар сурталчлах, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэхэд чиглэсэн олон хэлбэрийн ажил зохион байгуулж, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг өргөн хүрээтэй оролцуулахыг Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Г.Эрдэнэтөгс/, Хууль зүйн хэлтэс /Л.Батсайхан/, Эрүүл мэндийн газар /Р.Байгалмаа/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчилдэг дэлгүүрийг 21 цаг, кафе, баар, эсгийг газрын 24 цагаас хойш үйлчилдэг байхаар цагийн хуваарьт хязгаарлалт тогтоосугай.

*/2012 оны 04 дүгээр сарын 18-ны 128 тоот захирамжаар хүчингүй болсон./*

4. Стандарт, чанарын шаардлага хангаагүй согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн, ажиллах цагийн хуваарийг зөрчсөн, түүнчлэн насанд хүрээгүй хүүхдэд согтууруулах ундаа худалдсан, түүгээр үйлчилсэн нь хууль, хяналтын байгууллагын шалгалтаар тогтоогдвол уг байгууллагуудын дүгнэлтийг үндэслэн аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч ажиллахыг аймгийн комисс /Д.Сүхбаатар/-т даалгасугай.

5. Энэ захирамжийн 1,3 дахь заалтын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн хэлтсийн дарга Л.Батсайхан, Цагдаагийн газрын дарга Ц.Баярсайхан, Мэргэжлийн хяналтын албаны дарга Л.Энхтуяа нарт даалгасугай.

АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА

Ч.ЭРДЭНЭБААТАР